



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 13

Есөнбулаг сум

**Хөрөнгө шилжүүлэхийг
зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 55 дугаар тогтоол, 2016 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын хуучин барилга нь аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт шилжсэнтэй холбогдуулан тус барилгад хамааралтай ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заагдсан 6 нэр төрлийн 14182100 төгрөгийн балансын анхны үнэ бүхий үндсэн хөрөнгийг Боловсрол, соёл урлагийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. Боловсрол, соёл урлагийн газарт шилжүүлсэн хуучин барилгын засварын асуудлыг яаралтай шийдвэрлэж, хөрөнгийн эзэмшил, ашиглалтыг сайжруулан, байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д үүрэг болгосугай.

3. Шилжүүлсэн өмч эд хөрөнгийг хүлээлцэн, холбогдох байгууллагуудтай хамтран хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль, журмын дагуу хийж гүйцэтгэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газар /З.Мөнхнасан/-д даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 02 сарын 14 -ны өдрийн
13 дугаар тогтоолын хавсралт

Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгаас
Боловсрол, Соёл Урлагийн Газарт
балансаас балансад шилжүүлэх
хөрөнгийн жагсаалт

/төгрөг/

д/д	Тавилгын нэрс	Тоо хэмжээ	Ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг
1	Яамны таг	ш	1	51,600.00	51,600.00	51,600.00	-
2	Дуучдын шкаф	ш	9	74,455.56	670,100.00	670,100.00	-
3	Үзэгчдийн сандал	ш	368	35,150.00	12,935,200.00	12,935,200.00	-
4	Регулятор	ш	1	390,700.00	390,700.00	390,700.00	-
5	Тайзны шат	ш	1	14,500.00	14,500.00	14,500.00	-
6	Гадна үүдний хаалга	ш	1	120,000.00	120,000.00	64,000.00	56,000.00
			381	686,405.56	14,182,100.00	14,126,100.00	56,000.00